



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛИЙН ЗӨВЛӨМЖ

2016 оны 10 сарын 24 өдөр

Дугаар 37/22

Улаанбаатар хот

Эдийн засгийн хүндрэлийг даван туулах,
тогтворжуулах хөтөлбөрийн төслийн тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөл Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах хөтөлбөрийн төслийн тухай Монгол Улсын Сангийн сайд Б.Чойжилсүрэнгийн илтгэлийг хэлэлцээд ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Засгийн газарт:

1. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах хөтөлбөрийн төслийг хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан, хугацаа болон санхүүгийн эх үүсвэрийг тодорхой болгон дахин боловсруулж Монгол Улсын Их Хуралд оруулж хэлэлцүүлэх.

2. Хувийн хэвшлийг дэмжих, бизнесийн болон гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах бодлого хэрэгжүүлэх.

3. Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах арга хэмжээг авахдаа Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд нийцүүлэх.

Хоёр. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн даргад:

Эдийн засгийн хүндрэлийг даван туулах, тогтворжуулах хөтөлбөрийн талаар гаргасан Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллах.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

МОНГОЛ УЛСЫН ИХ
ХУРЛЫН ДАРГА

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД

Ц.ЭЛБЭГДОРЖ

М.ЭНХБОЛД

Ж.ЭРДЭНЭБАТ

ХУУЛБАР ҮНЭН: НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ц.ЭНХТҮВШИН

0040059